

**БЕЛАРУСЬ:**

**ЭМИЛЬ ОСТРОВКО**

# ЭРХ ЧӨЛӨӨГ МӨРӨӨДӨН ХОРИГДОЖ БУЙ ӨСВӨР НАСНЫ ХҮҮ

ЭРХИЙНХЭЭ  
ТӨЛӨӨ  
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ



# ЭМИЛЬ ОСТРОВКО

## БЕЛАРУСЬ

2018 оны 4-р сарын нэгэн өдөр Эмиль Островко Минск хотын захын нэгэн автобусны буудал дээр найз охиноо хүлээн зогсож байтал гэнэт хэдэн цагдаа гарч ирэн, хууль бус мансууруулах бодис тараасан хэргээр Эмилиийг зодож, баривчилжээ. Тэр үед хүү ердөө 17 настай байв.

2018 оны эхээр Эмиль хичээлийнхээ дараа цахим худалдааны компанид хүргэлтийн ажил хийж байсан ба ажил олгогч нь тэдний бараанууд нь хуулиар зөвшөөрөгдсөн тамхины хольц агуулсан хэмээн хэлсэн байдаг.

Хэдэн сар хорьсны эцэст Эмильд мансууруулах бодис наймаалсан хэргээр 10 жилийн хорих ял оногдуулсан ч хожим нь заримыг нь хэрэгсэхгүй болгосноор 8 жилийн ял болгожээ. Мөрдөн байцаагчид цахим худалдаа эрхэлж байсан компанийн эздийг огт хайгаагүй, зөвхөн Эмилиийг л яллажээ.

Эмиль ном унших, сурах дуртай, охин дүүгээ асардаг, цовоо сэргэлэн, халамжтай нэгэн юм. Харин одоо ахлах сургуулиа ч төгсөж чадахгүй, их сургуульд орох төлөвлөгөө нь ч нуржээ.

Беларусьт жижиг хэмжээний мансууруулах бодисын хэргээр 15000 орчим хүн удаан хугацаагаар хоригдож байгаагийн нэг нь Эмиль юм. Тэдэнтэй бусад хоригдлуудаас илүү дор харьцаж, уртасгасан цагаар хүнд хөдөлмөр хийлгэдэг байна. Эмиль нүцгэн гараараа цас цэвэрлэж, гараа хөлдөөж байв. Насанд хүрэгчдийн хорих анги руу шилжсэний дараа түүний нөхцөл байдал ялимгүй дээрдсэн ч, залуу нас, бусад олон боломжуудаа алдаад байна.

## БЕЛАРУСЫЙН ЭРХ БАРИГЧ НАРТ ХАНДАН ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭЭ.

Эмилиийг нэн даруй суллаж, түүнд тулгасан эрүүгийн гэмт хэргийг цагаатгахыг уриалан, жижиг хэмжээний мансууруулах бодисын хэргээр насанд хүрээгүйчүүдийг хорихгүй байхыг шаардацгаая.

*Prosecutor General of the Republic of Belarus  
Internatsionalnaya Str. 22,  
220030  
MinskBelarus  
Email:  
info@prokuratura.gov.by  
Twitter: @prokuraturaby  
Salutation:  
Dear Prosecutor General*

## ЭМИЛИЙГ ДЭМЖИЖ БҮЙГАА ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ

Түүнд эв санааны нэгдлээ илэрхийлсэн зурвас илгээгээрэй.

**Emil Vadimovich Ostrovko**  
Correctional Colony Number 2  
Ul. Sikorskogo 1, otryad 1  
Bobruisk  
Mogilevskaya oblast  
213800  
Belarus

**ЗАХИДАЛ БИЧИЖ  
ВӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭ**

December 2019  
Index: EUR 49/0754/2019 English  
Images: cover: © Private (Main image)  
© Getty/Yaroslav Mikheev  
© diasUndKompott (CC)  
Back page: © iStock/ Alex Potemkin